



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ**

2019 оны 01 сарын 31 өдөр

Дугаар 08

Номгон

Г **Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих  
сангийн хөрөнгийг “Баянхонгор үйлдвэржилт  
хөгжлийн корпораци”-д хариуцуулж, хорооны  
бүрэлдэхүүнийг шинэчлэн томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалтыг үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Баянхонгор аймгийн Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн 2012-2016 оны зээлийн хөрөнгийг “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци”-ийн харьяанд шилжүүлэн хариуцуулсугай.

2. Орон нутгийн төсөв, олон улсын байгууллага, аж ахуйн нэгж байгууллагын хандив, дэмжлэг тусlamжаас жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор олгосон хөрөнгийг тус санд төвлөрүүлэн, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн өр авлагыг барагдуулах шат дараалан арга хэмжээ авч ажиллан хороогоор хуваарилуулж үр дүнг жил бурийн 12 дугаар сард аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдэд тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д даалгасугай.

3. Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн төсөл сонгон шалгаруулах зээлийн хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн томилсугай.

Дарга-Аймгийн Засаг дарга

Нарийн бичгийн дарга-Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпорацийн гүйцэтгэх захирал

Баянхонгор аймаг дахь Худалдаа аж үйлдвэрийн танхимын тэргүүн  
Аймгийн ажил олгогч эздийн холбооны тэргүүн  
Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга

Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга

Баянхонгор аймаг дахь Монгол банкны захирал

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтсийн дарга

“Сүлдэн Тэнгэр” хоршооны захирал И.Батгэрэл

“Гал Хонгор” ХХК-ний захирал Д.Сайнжаргал

Бичил бизнес эрхлэгчдийн төлөөлөл /хорооны нарийн бичгийн даргын санал болгосноор тухай бүр нь сонгож байх/

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөлгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч /Т.Эрдэнэбат/-д үүрэг болгосугай.

5. Аймгийн Иргэдийн төлөөлөлгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 97 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

